

Төлөвлөгөөг хянасан:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ
(албан тушаал)

Тэмдэг

Төлөвлөгөө баталсан:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ
ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн Ерөнхийлөн захирагч

Х.Нямбаатар
.....
(гарын үсэг)

(Х.НЯМБААТАР)

(огноо)

Төсвийн Шууд захирагч

В.Оюумаа
.....
(гарын үсэг)

(В.ОЮУМАА)

(огноо)

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж |
|---|--|-----------------|------------------|--------------|-----------------|-----------------------|---------------------|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| Зорилго 1. Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана. | | | | | | | |
| 1 | Зорилт 1. Нийслэлийн орлого, санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулна. | | | | | | |
| 1.1 | Арга хэмжээ 1.1. НХТЖҮЧ-7.1.8.1 Орон нутгийн өмчит орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн өгөөж (ROA) | - | Хувь | 2,0 | 2,5 | I-IV улирал | ӨУЗХ |
| 1.2 | Арга хэмжээ 1.2. НХТЖҮЧ-7.1.8.1 Орон нутгийн өмчийн ашиглалтын орлого (түрээс, дуудлага худалдаа, акталсан бараа) | - | Тэрбум төгрөг | 6,7 | 54,4 | I-IV улирал | ЗУХ ӨХШХ ӨУЗХ |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж |
|--|--|-----------------|--|--------------|--|-----------------------|---------------|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.3 | Арга хэмжээ 1.3. НХТЖҮЧ-7.1.8.2 Өмч эзэмшүүлэх гэрээний биелэлт дэх ил тод байдлын үнэлгээ (Улсын дундаж) | - | Хувь | 50% | 55% | I-IV улирал | ӨУЗХ ӨХШХ |
| 1.4 | Арга хэмжээ 1.4. НЗДҮАХ 3.2.5 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эзэмшилд байгаа хөрөнгийн бүртгэл, тооллогыг зохион байгуулж, өмчийн бүрэн бүтэн байдал, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллах ^{НХ2026} | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100 хувь | I-IV улирал | ӨУЗХ ӨХШХ |
| 1.5 | Арга хэмжээ 1.5. ЗДҮАХ-3.2.5 Нийслэлийн өмчийн бүртгэлийн удирдлагын системд нийслэлийн өмчит хуулийн этгээдийн өмчийн мэдээллийг бүртгэх ^{ЗД2024-2028} | - | Мэдээлэл боловсруулах ажлын явц хувь | - | 100% | I-IV улирал | ӨУЗХ ӨХШХ |
| 1.6 | Арга хэмжээ 1.6. ЗДҮАХ-3.2.5 Орон нутгийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх ^{ЗД2024-2028} | - | Эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын гүйцэтгэлийн хувь | 20% | 40% | I-IV улирал | ӨУЗХ |
| Зорилго 2. Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг ханган ажиллана. (Хуулиар тусгайлан олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилго) | | | | | | | |
| 2 | Зорилт 2. Нийслэлийн өмчийн харилцааны менежментийн оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх замаар өмчийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах, эдийн засгийн чадавхыг дээшлүүлнэ. | | | | | | |
| 2.1 | Арга хэмжээ 2.1 Нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ), нийслэлийн өмчийн хуулийн этгээдийн Удирдах зөвлөлийн (УЗ) гишүүнийг томилох, чөлөөлөх, өөрчлөлт оруулах санал боловсруулж НИТХ-д өргөн барьж шийдвэрлүүлэх | - | Хуулийн этгээдийн тоо, гишүүдийн тоо | 4 173 | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж шийдвэрлүүлсэн байна. | I-IV Улирал | ӨУЗХ |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж |
|-----|--|-----------------|---|--------------|-----------------|-----------------------|---------------|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 2.2 | Арга хэмжээ 2.2 Нийслэлийн Өмч хувьчлалын комисс (НӨХК)-ын хурлыг зохион байгуулах, хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтыг НИТХ-д өргөн барьж шийдвэрлүүлэх | - | Зохион байгуулсан хурал, тогтоолын тоо | 5 3 | 6 4 | I-IV улирал | ӨУЗХ |
| 2.3 | Арга хэмжээ 2.3 НИТХ-ын тогтоолоор батлагдсан хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтын дагуу нийслэлийн өмчийг хувьчлах ажлыг зохион байгуулах | - | Хувьчилсан эд хөрөнгийн тоо, | 3 | 4 | I-IV улирал | ӨУЗХ |
| 2.4 | Арга хэмжээ 2.4 ОНӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг дүгнэх ажлыг зохион байгуулж, үнэлгээг нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулах | - | ОНӨААТҮГ-ын тоо | 24 | 24 | I-IV улирал | ӨУЗХ |
| 2.5 | Арга хэмжээ 2.5 ОНӨААТҮГ-ын 2026 оны эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшнийг батлуулах ажлыг зохион байгуулж, нийслэлийн Засаг даргын захирамжаар баталгаажуулах | - | ОНӨААТҮГ-ын тоо | 24 | 24 | I-IV улирал | ӨУЗХ |
| 2.6 | Арга хэмжээ 2.6 ОНӨААТҮГ-ын захиралтай “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ” байгуулах ажлыг зохион байгуулах | - | Гэрээ байгуулсан ОНӨААТҮГ -ын тоо | 24 | 24 | I-IV улирал | ӨУЗХ |
| 2.7 | Арга хэмжээ 2.7 Нийслэлийн өмчийн болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2025 оны санхүүгийн тайлангийн цэвэр ашгаас 2026 онд нийслэлийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хувь хэмжээг тогтоон, НИТХ-аар батлуулах | - | Хуулийн этгээдийн тоо, ногдол ашгийн дүн, сая төг | 8 2,047 | 8 2,0 | I-IV улирал | ӨУЗХ |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж |
|------|---|-----------------|--|--------------|--|-----------------------|--------------------|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 2.8 | Арга хэмжээ 2.8 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газруудыг шинээр байгуулах, татан буулгах, өөрчлөн байгуулах ажлыг зохион байгуулан, дүрэм, бүтэц, орон тоог судлан санал боловсруулж, НИТХ, Нийслэлийн Засаг даргад өргөн барьж шийдвэрлүүлэх | - | Өөрчлөн байгуулсан хуулийн этгээдийн тоо | 2 | 3 | I-IV улирал | ӨУЗХ |
| 2.9 | Арга хэмжээ 2.9 Нийслэлийн өмчийн төсөвт байгууллагын удирдлагатай байгуулсан "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2025 оны биелэлтийг дүгнэх | - | Хамрагдсан байгууллагын тоо | - | 400 | I-IV улирал | ӨУЗХ |
| 2.10 | Арга хэмжээ 2.10 "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ" байгуулах ажлыг зохион байгуулах | - | Гэрээ байгуулсан байгууллагын тоо | 13 | 15 | I-IV улирал | ӨУЗХ |
| 2.11 | Арга хэмжээ 2.11 Нийслэлийн өмчийн байр талбайн ашиглалтыг сайжруулж, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн илүүдэлтэй байр, талбайг иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах | - | Түрээсийн гэрээний тоо, | 411 | 420 | I-IV улирал | ЗУХ |
| 2.12 | Арга хэмжээ 2.12 Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах, бусад хуулийн этгээдийн комисст орж ажиллан, хяналт тавих | - | Сонгон шалгаруулалтын тоо | 45 | 50 | I-IV улирал | ЗУХ ХЗХ ӨХШХ |
| 2.13 | Арга хэмжээ 2.13 Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаад дотоодын зээл, төсөл хөтөлбөр, хандив бэлэглэлээр шинээр бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэх, хүлээн авах ажлын хэсэгт орж ажиллах | - | Бүртгэсэн хөрөнгийн дүн, сая төгрөг | 504,542.8 | Тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж ажилласан байна | I-IV улирал | ӨУЗХ ӨХШХ |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж |
|------|---|-----------------|-----------------------------------|--|---|-----------------------|---------------|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 2.14 | Арга хэмжээ 2.14 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн баланст бүртгэлтэй хөрөнгийг акталж, данснаас хасах асуудлыг шийдвэрлүүлэх | - | Хассан хөрөнгийн дүн, сая төг | 32,410.8 | НИТХ-ын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, ҮХХХК-ын шийдвэрээр хассан байна. | I-IV улирал | ӨУЗХ |
| 2.15 | Арга хэмжээ 2.15 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн баланст бүртгэлтэй хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх | - | Шилжүүлсэн хөрөнгийн дүн, сая төг | 125,767.3 | НИТХ-ын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, ҮХХХК-ын шийдвэрээр шилжүүлсэн байна. | I-IV улирал | ӨУЗХ |
| 2.16 | Арга хэмжээ 2.16 Хувийн хөрөнгө оруулалтаар бий болсон, нийслэлд үнэ төлбөргүй шилжүүлэн өгч байгаа нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авч, ашиглалт хариуцсан байгууллагад хүлээлгэн өгөх асуудлаар санал боловсруулах, хэрэгжилтийг хангах | - | Хөрөнгийн дүн, сая төг | 3,470.8 | НИТХ-д өргөн барьж шийдвэрлүүлсэн байна. | I-IV улирал | ӨУЗХ |
| 2.17 | Арга хэмжээ 2.17 Хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн судалгааг ангилал бүрээр гаргах | - | Хөрөнгийн дүн, сая төг | 13,262,186.2 | Хөрөнгийн судалгааг ангилал бүрээр гаргасан байна. | I-IV улирал | ӨУЗХ |
| 2.18 | Арга хэмжээ 2.18 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эрх шилжүүлсэн ажилд захиалагчийн хяналт тавих, захиалагчийн хяналт тавьсан төсөл, арга хэмжээний 5%-ийн барьцаа хөрөнгийг чөлөөлөх | - | Хөрөнгийн дүн, сая төгрөг | Захиалагчийн хяналт - Барьцаа чөлөөлөх 26.6 | Эрх шилжүүлсэн ажлын захиалагчийн хяналтыг тавьж хөрөнгө хүлээлгэн өгч, санхүүжилтийг олгосон байна. Ашиглагч байгууллагын хүсэлтийн дагуу барьцаа хөрөнгө чөлөөлсөн байна. | I-IV улирал | ӨХШХ ЗУХ |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж |
|------|---|-----------------|--|---|---|-----------------------|----------------------------|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 2.19 | Арга хэмжээ 2.19 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг Өмчийн харилцааны газрын дэргэдэх "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын хурлаар хэлэлцүүлэн, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих | - | Байгууллагын тоо, Хөрөнгийн дүн, сая төгрөг | 692 96,505.89 | Хөрөнгийн хөдөлгөөний асуудлыг хэлэлцэж шийдвэрийг нийслэлийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлсэн байна | I-IV улирал | ҮХХХ Комисс ӨХШХ |
| 2.20 | Арга хэмжээ 2.20 Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, хөрөнгийн хөдөлгөөнийг баталгаажуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Үндэсний статистикийн хороонд хүргүүлэх | - | Хуулийн этгээд, хөрөнгийн дүн, их наяд төг | Хуулийн этгээд 889 Сан 44 11.2 | Хуулийн этгээд 889 Сан 44 11.2 | I-II улирал | ӨУЗХ |
| 2.21 | Арга хэмжээ 2.21 Нийслэлийн Засаг даргын захирамжаар данснаас хассан тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлага худалдаагаар худалдах ажлыг зохион байгуулах | - | Зохион байгуулсан тоо Дүн, сая төгрөг | 2 61,886 | Засаг даргын захирамжийн дагуу дуудлага худалдааг зохион байгуулна. | I-IV улирал | Ажлын хэсэг |
| 2.22 | Арга хэмжээ 2.22 Нийслэлийн өмчтэй холбоотой шүүхийн маргаанд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргыг төлөөлж оролцох | - | Шүүхийн маргааны тоо, Эцэслэн шийдвэрлэсэн маргааны тоо | 4 0 | 4 4 | I-IV улирал | ХЗХ |
| 2.23 | Арга хэмжээ 2.23 Нийслэлийн өмчтэй холбогдон гарсан зөрчил, маргаанд байгууллагыг төлөөлөн оролцох, | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | I-IV улирал | ХЗХ |
| 2.24 | Арга хэмжээ 2.24 Холбогдох хууль, тогтоомжийн төсөлд санал өгөх, өмчтэй холбоотой хууль, дүрэм, журмыг сурталчлан таниулах, арга зүйгээр хангах | - | Саналын тоо Хэрэгжилтийн хувь | 15 100% | 100% | I-IV улирал | ХЗХ ЗУХ ӨУЗХ ӨХШХ |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж |
|---|---|-----------------|-----------------------------------|--------------|-----------------|-----------------------|----------------------------|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 2.25 | Арга хэмжээ 2.25 НИТХ-ын тогтоол, нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан нийслэлийн хэмжээнд дагаж мөрдөж байгаа нийслэлийн өмчийн эрх зүйн акт, дүрэм, тогтоол, журмын төслийг шинэчлэн боловсруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | I-IV улирал | ХЗХ ЗУХ ӨУЗХ ӨХШХ |
| 2.26 | Арга хэмжээ 2.26 Нийслэлийн өмчийг эзэмшин үйл ажиллагаа явуулж байгаа аливаа хуулийн этгээдийн өмчийн эзэмшилт, өөрчлөлт, захиран зарцуулалт, ашиглалтад эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалт хийх төлөвлөгөө батлан хэрэгжилтийг ханган ажиллах | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | 100% | I-IV улирал | ӨХШХ |
| Зорилго 3. Хуулиар олгогдсон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 3 | Зорилт 3. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, эрх зүйн баримтуудыг шинэчлэн боловсруулна. | | | | | | |
| 3.1 | Арга хэмжээ 3.1 Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж НЗДТ-т тайлагнах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | I-IV улирал | ӨХШХ ЗУХ ХЗХ ӨУЗХ |
| 3.2 | Арга хэмжээ 3.2 Хяналт шалгалтын байгууллага, дээд байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах | - | хэрэгжилтийн хувь | 100% | 100% | I-IV улирал | ӨХШХ ЗУХ ХЗХ ӨУЗХ |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж |
|-----|---|-----------------|--|--------------|-----------------|-----------------------|----------------------------|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 3.3 | Арга хэмжээ 3.3 НЭДТГ Монгол Улсын сангийн сайдын 2023.12.25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнах | - | Ажил, үйлчилгээний тоо, хөрөнгийн дүн, сая төг | - | 2 78.5 | I-IV улирал | ЗУХ ХЗХ ӨУЗХ ӨХШХ |
| 3.4 | Арга хэмжээ 3.4 НЭДТГ Байгууллагын шаардлагатай журмуудыг шинээр болон шинэчилж боловсруулах, хэрэгжилтийг хангах, журмын хяналтын тогтолцоог сайжруулах | - | Журмын тоо | - | 10 | I-IV улирал | ХЗХ ЗУХ ӨУЗХ ӨХШХ |
| 3.5 | Арга хэмжээ 3.5 НЭДТГ Байгууллагын дотоод болон гадаад (сонирхогч талууд) хэлэлцүүлэг зохион байгуулах тогтолцоог боловсронгуй болгох, хөгжүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100% | I-IV улирал | ХЗХ ЗУХ ӨУЗХ ӨХШХ |
| 3.6 | Арга хэмжээ 3.6 НЭДТГ Байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээний тогтолцоо(KPI) -г сайжруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100% | I-IV улирал | ӨХШХ |
| 3.7 | Арга хэмжээ 3.7 НЭДТГ ISO 9001 чанарын удирдлагын тогтолцооны стандарт нэвтрүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100% | I-IV улирал | ЗУХ ХЗХ ӨУЗХ ӨХШХ |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж |
|------|---|-----------------|--------------------------------------|--------------|-----------------|-----------------------|----------------------------|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 3.8 | Арга хэмжээ 3.8 НЗДТГ Хотын хөгжлийн индекс дэх өөрийн байгууллагад хамааралтай индексийг сайжруулах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100% | I-IV улирал | ӨХШХ |
| 3.9 | Арга хэмжээ 3.9 Жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг Дэмжих зорилгоор Нийслэлийн өмчийн илүүдэлтэй байр талбайг нээлттэй сонгон шалгаруулалт зарлан түрээслэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100% | I-IV улирал | ЗУХ ХЗХ ӨУЗХ ӨХШХ |
| 3.10 | Арга хэмжээ 3.10 "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намар мод тарих | - | Модны тоо | 180 | 185 | I-IV улирал | ЗУХ ХЗХ ӨУЗХ ӨХШХ |
| 4 | Зорилт 4. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг бүрэн хангана. | | | | | | |
| 4.1 | Арга хэмжээ 4.1 НЗДТГ Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 100% | 100% | I-IV улирал | ЗУХ ХЗХ ӨУЗХ ӨХШХ |
| 4.2 | Арга хэмжээ 4.2 НЗДТГ Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2030он)-г хэрэгжүүлж, Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | I-IV улирал | ЗУХ ХЗХ ӨУЗХ ӨХШХ |
| 5 | Зорилт 5. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | | | | | | |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж |
|-----|---|-----------------|---|--------------|-----------------|-----------------------|----------------------------|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 5.1 | Арга хэмжээ 5.1 НЗДТГ Төрийн албан хаагчид ёс зүйн асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, удирдамж, заавраар хангах, сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах боломж, нөхцөл бүхий орчныг бүрдүүлж, Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | I-IV улирал | Ёс зүйн дэд хороо |
| 5.2 | Арга хэмжээ 5.2 НЗДТГ Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлэх, хэвшүүлэх, баримтлан ажиллахад чиглэсэн үйл ажиллагааг байгууллагын удирдлага манлайлан, Ёс зүйн дэд хорооны дэмжлэгтэйгээр тогтмол хэрэгжүүлнэ | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | I-IV улирал | Ёс зүйн дэд хороо |
| 5.3 | Арга хэмжээ 5.3 НЗДТГ Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэхэд иргэний нийгэм, хувийн хэвшил, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | I-IV улирал | Ёс зүйн дэд хороо |
| 6 | Зорилт 6. Мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл технологийг сайжруулна. | | | | | | |
| 6.1 | Арга хэмжээ 6.1 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын жилийн төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг ханган ажиллах | - | Төлөвлөгөөний арга хэмжээний тоо, гүйцэтгэлийн хувь | 41 100% | 41 100% | I-IV улирал | ЗУХ ХЗХ ӨУЗХ ӨХШХ |
| 6.2 | Арга хэмжээ 6.2 Нийслэлийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд UBlegal.ulaanbaatar.mn цахим хуудаст захирамжлахын баримтуудын баяжилтыг хийх | - | Оруулсан тушаалын тоо | 627 | 627 | I-IV улирал | ЗУХ |
| 6.3 | Арга хэмжээ 6.3 Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллаж, хяналт шинжилгээ үнэлгээ хийж НЗДТГ-т тайлагнах | - | Үүрэг даалгаврын тоо, гүйцэтгэлийн хувь | 79 100% | - 100% | I-IV улирал | ЗУХ ХЗХ ӨУЗХ ӨХШХ |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж |
|-----|---|-----------------|-----------------------------------|--------------|-----------------|-----------------------|----------------------------|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 6.4 | Арга хэмжээ 6.4 нэдтг Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд бий болдог захиргааны болон албан ёсны статистикийн мэдээллийн бэлэн байдлыг сайжруулах. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100% | I-IV улирал | ЗУХ ХЗХ ӨУЗХ ӨХШХ |
| 7 | Зорилт 7. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангана. | | | | | | |
| 7.1 | Арга хэмжээ 7.1 Нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдсан бүтэц, орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, чөлөөлөх, шагнаж урамшуулах, хариуцлага тооцох зэрэг хүний нөөцийн үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | I-IV улирал | ЗУХ |
| 7.2 | Арга хэмжээ 7.2 Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2026 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг үе шаттайгаар төлөвлөн ажиллах, тайлагнах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | I-IV улирал | ЗУХ |
| 7.3 | Арга хэмжээ 7.3 Байгууллагын албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | I-IV улирал | ЗУХ |
| 7.4 | Арга хэмжээ 7.4 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | I-IV улирал | ЗУХ |
| 8 | Зорилт 8. Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, санхүүгийн сахилга хариуцлагыг баримтлан, ил тод байдлыг ханган ажиллана. | | | | | | |

| Д/Д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая.төг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж |
|-----|---|-----------------|---|---|---|-----------------------|----------------------------|
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 8.1 | Арга хэмжээ 8.1 Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын дагуу шилэн дансны мэдээллийг https://shilendans.gov.mn/ цахим системд цаг хугацаанд нь байршуулах | - | Мэдээллийн тоо, Хэрэгжилтийн хувь | 170 100% | 171 100% | I-IV улирал | ЗУХ |
| 8.2 | Арга хэмжээ 8.2 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах | - | Төсвийн санхүүжилт, гүйцэтгэлийн дүн, сая төг | Санхүүжилт 3,197.7 Гүйцэтгэл 1,936.2 | Санхүүжилт 3,601.4 Гүйцэтгэл - | I-IV улирал | ЗУХ |
| 8.3 | Арга хэмжээ 8.3 Нийслэлийн өмчит үйлдвэрийн газарт олгосон нэмэлт санхүүжилтийг хуваарийн дагуу зарцуулах | - | Санхүүжилтийн дүн, Гүйцэтгэлийн хувь | 51,577.6 100% | - 100% | I-IV улирал | ЗУХ |
| 9 | Зорилт 9. Албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, баримт бичгийн эмх цэгц, бүрдэл, хадгалалт, ашиглалтыг сайжруулна. | | | | | | |
| 9.1 | Арга хэмжээ 9.1 Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллах, албан хэргийг хос бичгээр хөтлөх, албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх, | - | Албан бичиг, өргөдөл гомдлын тоо, хэрэгжилтийн хувь | Албан бичиг 4194, 90.66% Өргөдөл 165, 100% | Албан бичиг, өргөдлийг 100% шийдвэрлэсэн байна. | I-IV улирал | ЗУХ ХЗХ ӨУЗХ ӨХШХ |
| 9.2 | Арга хэмжээ 9.3 Архивын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, байгууллагын архивын сан хөмрөгийг бүрдүүлэх | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100% | 100% | I-IV улирал | ЗУХ ХЗХ ӨУЗХ ӨХШХ |

----oOo----

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧДААС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
АГЕНТЛАГИЙН УДИРДЛАГАТАЙ БАЙГУУЛАХ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2026 оны 2 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар: 01/60

Улаанбаатар хот

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөө, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/62 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын "2026 оныг Бизнес эрхлэгчдийг дэмжих жил болгон зарлах тухай" 2026 оны А/01 дүгээр захирамжийн дагуу хэрэгжүүлж байгаа арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, үндэсний үйлдвэрлэгч, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, бүтээн байгуулагч зэрэг бизнес эрхлэгчдийг бүх талгаар дэмжих, Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэх, шударга, ил тод, хариуцлагатай, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлж, ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгаж, иргэдэд хүргэх төрийн болон нийгмийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, эцсийн үр дүнг үнэлж, гэрээг дүгнэхтэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон нэг талаас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар (цаашид "Нийслэлийн Засаг дарга" гэх), нөгөө талаас Нийслэлийн Өмчийн харилцааны газрын дарга В.Оюумаа нар (цаашид "Удирдах ажилтан", хамтад нь "Талууд" гэх) 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал 1 жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

1.3. Талууд Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2026 онд хамтран ажиллах гэрээ, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам", Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мөргөшлийн түвшнийг үнэлэх журам", Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам", Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор баталсан "Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам", Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны "Нийслэлийн 2026 оны төсөв батлах тухай" 25/133 дугаар тогтоол болон энэхүү гэрээний хугацаанд баталсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолыг тус тус хэрэгжүүлж ажиллана.

1.4. Нийслэлийн Засаг даргын 2026 оныг "Бизнес эрхлэгчдийг дэмжих жил болгон зарлах тухай" 01 дүгээр захирамжийн дагуу хэрэгжүүлж байгаа арга хэмжээг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, Үндэсний үйлдвэрлэгч, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч, бүтээн байгуулагч зэрэг бизнес эрхлэгчдийг бүх талаар дэмжиж ажиллана.

1.5. Тухайн байгууллагын "гүйцэтгэлийн төлөвлөгөө" нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд төсвийн шууд захирагчаас тухайн жилд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, төсөв, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилгот түвшин, хугацаа, хариуцах нэгжийг тусгана.

Хоёр. Удирдах ажилтны хүлээх үүрэг

2.1. Удирдах ажилтан энэхүү гэрээгээр дараах үүрэг хүлээнэ:

2.1.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, 2026-2030 онд Нийслэлийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;

2.1.2. Засгийн газрын гишүүнтэй Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч 2026 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, гэрээнд заасан хугацаанд тайлагнах;

2.1.3. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, төрийн жинхэнэ албанд хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх замаар төрийн албыг цомхон, тогтвортой, үр ашигтай, хариуцлагатай ажиллуулах, чадахуйн зарчим (мерит)-ыг тууштай хэрэгжүүлэх; төрийн албан хаагчийн хандлага, ёс зүйг дээшлүүлэх;

2.1.4. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг батлагдсан төсвийн хүрээнд хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах, өр, авлага үүсгэхгүй байх, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбоотой гэрээ, хэлцлийн биелэлт, үр дүнг тайлагнаж, Нийслэлийн Засаг даргын өмнө хариуцлага хүлээх;

2.1.5. Батлагдсан төсвийн хүрээнд сар, улирлын хуваарийн дагуу орлогын төлөвлөгөөг бүрэн хэмжээнд, хугацаанд нь төвлөрүүлэх;

2.1.6. Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр хугацаанд нь тайлагнах;

2.1.7. Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг хөтөлж, зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу хуульд заасан хугацаанд тайлагнах;

2.1.8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, "Нийслэлийн өмчийг эзэмшүүлэх гэрээ", нийслэлийн өмчит болон өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлагатай байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-гээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх;

2.1.9. Хууль, дүрмээр болон энэхүү гэрээгээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, Нийслэлийн Засаг даргыг шүүхийн маргаанд итгэмжлэлээр төлөөлөх, үр дүнг хариуцан тайлагнах;

2.1.10. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон хотын аж ахуйн нэгдмэл байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хотын аж ахуй, инженер хангамжийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилтийг Улаанбаатар хотын Ерөнхий менежертэй зөвшилцөж ажиллах;

2.1.11. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Нийслэлийн Засаг дарга баталж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээний актыг Захираганы ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх, батлагдсан дүрэм, журам, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

2.1.12.Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж бодит үр дүнг дээшлүүлэх, тогтоосон хугацаанд тайлагнах;

2.1.13.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

2.1.14.алба хаагчдын сахилга хариуцлага, хандлага, ёс зүй, мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулж ажил, арга хэмжээ зохион байгуулах;

2.1.15.төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн, үр дүнг нэмэгдүүлэх;

2.1.16.холбогдох хууль тогтоомжийн хүрээнд нийслэлийн удирдлагын шийдвэр, удирдамжийн дагуу хийгдэж буй албаны, хэсэгчилсэн, гүйцэтгэлийн шалгалтын үеэр хяналт хэрэгжүүлэх нэгж, албан тушаалтны хууль ёсны шийдвэрийг биелүүлэх;

2.1.17.Нийслэлийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31-ний А/1024 тоот захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийг тооцох 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтүүдийн суурь түвшинг тодорхойлж, үзүүлэлтийн үр дүнг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх бөгөөд хэрэгжилтийн хүрсэн үр дүнг жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцож тайлагнах, 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх;

2.1.18.чиг үүргийн хүрээний үндэсний болон хотын стандарт, нормын хэрэгжилтийг хариуцан, иргэн, хуулийн этгээдэд сурталчлан таниулж мөрдүүлэх, хяналт тавих, тухай бүр тайлагнаж бодит үр дүнг сайжруулах;

2.1.19.байгууллага, аж ахуй нэгж, албан хаагчдын төлөвлөлтийн баримт бичгийг тогтвортой хөгжилд түшиглэсэн засаглалын шинэчлэлийн хүрээтэй уялдуулан боловсруулах, хэрэгжилтийг хангах, хэрэгжилтийн явц, үр дүнг тогтмол хянах, залруулах арга хэмжээг тухай бүр авч ажиллана;

2.1.20.аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгөх, хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, тодорхой арга хэмжээ авах;

2.1.21.Нийслэлийн удирдлагуудаас өгсөн үүрэг, даалгаврыг нэн даруй биелүүлж, явц үр дүнг тайлагнах, Нийслэлийн удирдлага, Засаг даргын Тамгын газраас хүргүүлсэн чиглэл, албан бичгийн хариуг шуурхай өгөх, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2.1.22.энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгалдсан нийт арга хэмжээний биелэлтийг арга хэмжээ нэг бүрээр хэрэгжүүлэн холбогдох журамд заасан хугацаанд тайлагнах;

2.1.23.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Нээлтэй мэдээлэл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 46 дугаар зүйлд заасан байгууллагын даргын шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын гурван өдрийн дотор бүрэн эхээр нь цахим хуудаст байршуулж, олон нийтийг танилцах боломжоор хангах;

2.1.24.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах;

2.1.25.гадаад харилцааны чиглэлийн үйл ажиллагаа, арга хэмжээний талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны газраас урьдчилан зөвшөөрөл авч, хэрэгжүүлэх;

2.1.26.хариуцсан чиг үүргийн хүрээний асуудлаар хэрэгжүүлж байгаа аливаа арга хэмжээний талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл

мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэстэй зөвшилцөж, мэдээллийг нэгдсэн нэг урсгалаар түгээх:

Гурав. Нийслэлийн Засаг даргын хүлээх үүрэг

3.1. Нийслэлийн Засаг дарга энэхүү гэрээгээр дараах үүрэг хүлээнэ:

3.1.1. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний бүх шатны агентлаг, харьяа байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан үйлчилгээний шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж, хариуцлагыг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээг авах:

3.1.2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийн Хөгжлийн 2026 оны төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангах;

3.1.3. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн жинхэнэ албыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд сахилга, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авах;

3.1.4. төсвийн зардлыг хэмнэх, төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанар, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, удирдлага, зохион байгуулалтаар хангах;

3.1.5. худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд нутгийн захиргааны байгууллагуудад тогтмол зөвлөмж, чиглэл өгч, сургалт, мэдээллээр хангах;

3.1.6. эрх шилжүүлсний үндсэн дээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хуулийн хугацаанд олгох;

3.1.7. байгууллагын удирдлагатай байгуулсан гэрээг дүгнэхэд тухайн удирдах ажилтны иргэдэд цахимаар үзүүлсэн үйлчилгээний тоо, чанар, хүртээмжийг харгалзах, үйлчилгээ үзүүлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдах ажилтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцох;

3.1.8. ил тод, хэмнэлттэй, үр ашигтай төсвийн бодлогыг хэрэгжүүлж, төсвийн сахилга батыг чангатгах, төсвийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангуулах:

Дөрөв. Гэрээг дүгнэх

4.1. Гэрээний биелэлтийн хагас жилийн тайланг 2026 оны 06 дугаар сарын 25-ны дотор, бүтэн жилийн тайланг 2026 оны 12 дугаар сарын 15-ны дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус ирүүлнэ.

4.2. Гэрээний хавсралт болох "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний жилийн эцсийн биелэлтийг "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын дагуу үнэлнэ.

Тав. Гэрээний хариуцлага

5.1. Энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, гэрээний хавсралт болох "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээг дуутуу гүйцэтгэсэн, өмнөх үр дүнг бууруулсан, хүрэх түвшинд хүргээгүй, сахилга, хариуцлага алдсан, ёс зүйн зөрчил гаргасан бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэх үндэслэл болно.

Зургаа. Бусад зүйл

- 6.1. Талууд гэрээнд тусгагдсан үүргээ харилцан биелүүлнэ.
- 6.2. Гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд талууд харилцан бичгээр санал тавьж, зөвшилцөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 6.3. Гэрээнд өөрчлөлт орсон тохиолдолд гэрээг баталгаажуулан гарын үсэг зурж, хоёр хувь үйлдэх бөгөөд энэхүү өөрчлөлт нь энэ гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 6.4. Энэхүү гэрээг 2 хувь үйлдэж, талууд тус тус 1 хувийг хадгална.

Гэрээ байгуулсан:

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН
ХАРИЛЦАДНЫ ГАЗРЫН
ДАРГА

В.ОЮУМАА